

## МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ СУРЫН ХАРВАА (MYCX-НЫ ҮҮСЭЛ, ХӨГЖЛИЙН ТҮҮХИЙГ ҮЕЧЛЭХ АСУУДАЛД)

С.Батхуяг.

Монгол улсын Боловсролын их сургууль, Сурган хүмүүжүүлэх ухааны тэнхим.

**Өгүүллийн төвч утга:** Монголчуудын эрийн гурван наадмын салшгүй хэсэг бол үндэсний сурын харваа юм. Сурын харваа бол шинэ чулуун зэвсгийн үеэс үүсэлтэй. Эл спортын хөгжлийг Монголын түүхийн үндсэн үеүдтэй уялдуулан үечилж, үечлэл бүрийн гол онцлог, шалгуурыг гаргах зорилт тавьсан болно.

**Түлхүүр үг:** Сурын харваа, нум сум, булцуут сум, үечлэл, халх сур, буриад сур, урианхай сур.

Монголын үндэсний сурын харваа нь монголчуудын хүн төрөлхтөний ахуйн соёлд оруулсан хувь нэмрийн нэгээхэн хэсэг бөлгөө. Иймээс түүний үүсэл хөгжил нь монгол түмний нийгмийн хөгжилтэй салшгүй холбоотой болох нь гарцаагүй.

Гэхдээ MYCX-ны хөгжлийг үечлэн авч үзсэн бүтээл өдий хэр үгүй байгаа юм. Гэсэн ч сурын харваа судлалд түүний үүсэл хөгжлийн түүхийн асуудал зүй ёсоор өөрийн байр суурийг эзлэх нь лавтай. Иймд бид үүний эхлэл болгож, энэ спортын түүхэн хөгжлийн үечлэлийг асуудлыг хөндөх нь зүйтэй гэж үзлээ.

Сурын харваа нь чухамдаа нэг талаас өсвөр zaluu үөйиг бие бялдар, ёс суртахуун, оюун ухаан, гоо сайхны талаар хөгжүүлэх төлөвшүүлэх хэрэглүүр, нөгөө талаас цэрэг эрсийн зэр зэвсэг болж гарсан болж ирсэн болохлоор төр, нийгмийн тогтолцоотой нягт уялдаатай хөгжиж ирсэн байх учиртайг үндэслэл болгож, монгол үндэсний сурын харвааны үүсэл хөгжлийг монголын түүхийн үечлэлтэй уялдуулан авч үзэх нь учир зүйн хувьд ч шинжлэх ухааны хувьд ч зохицтой. Гэсэн ч түүхэн ахархан хугацаанд үндэсний сурын харвааны хувьд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан байх тул бид түүнийг ач холбогдол, үр нөлөөнийх нь хувьд тусгай үе болгон авч үзсэн болно.

Ямар ч гэсэн түүхэн үйл явцыг үечилнэ гэдэг нь нэг талаас түүх судлалын зайлшгүй шаардлага, нөгөө талаас судалгааны нэгэн аргачлал болох тул сурын харвааны судлалд ямар нэг хэмжээгээр ач холбогдолтой гэж үзэн, үечлэлийн нэгэн хувилбар болгож дараах үечлэлийг хийсэн болой.

**1.Нэн эртний үе.** Энэ үе нь нум сум үүсэж шинэ чулуун зэвсгийн үеэс анхны төр улс үүссэн манай эриний өмнөх III зууны хүртэлх үөйиг хамрах юм.

Нум сум үүсч бий болсон Сибирь, Байгаль нуур орчмын нутаг нь чухамдаа хожмын монгол туургатны өлгий нутгийн нэг хэсэг байсан учраас монгол угсаатан нь нум, сумыг энэ үеэс хэрэглэж эхэлсэн гэж үзэх үндэстэй.

Оросын судлаач А.П.Окладников Байгаль нуурын орчмоос МЭӨ 3000 жилд хамаарах нумын олдворыг олсон ба тэр үеэс зүймэл нумын түүх эхэлсэн гэж үзсэн байdag. /1/ Түүнчлэн Н.С.Счөев /1948/ Сибир-Монголын тал нутгаас Хятадад нум нэвтэрч хөгжсөн гэж тодорхойлсон нь ч бий. Энэ үед монголчууд нум сумыг ан агууруын зориулалттай голчлон ашиглаж байсан байж таарна.

А.Дамдинсүрэн өөрийн бүтээлдээ: "Хуучин чулуун зэвсгийн шувтарга, шинэ чулуун зэвсгийн эхэн үед Төв Азид амьдарч байсан хүмүүс /эдэн дунд Монголчууд ирж байх учиртай.С.Б/ өдөр тутмын амьдралынхаа шаардлагаар янз бүрийн зэрлэг амьтдыг агнахын тулд тэдэнтэй биеэр тулж авлах осолтой хэцүү хөдөлмөрийг хөнгөвчилсөн шинэ оньсон зэвсэг болох нум сум зохион бүтээжээ" /5,44/ гэсэн нь дээр өгүүлсэний баталгаа болох талтай.

Ж.Дамдин аbugай "... ан гөрөөнд их олз олсон овог тус бүрий тэр тухайдаа баяр хөөр болж, .. найр цэнгэл хийж, түүндээ аль мэргэн цэцэн харвадагаараа бай харвуулан сонирхох болжээ" гэж тэмдэглэсэн нь сур харваж наадахын эх суурь нэн эрт үеэс тавигдаж байсныг хэлсэн хэрэг юм.

Ф.Энгельс ч “Өрх гэр, хувийн өмч, териин үүсэл” зохиолдоо ч мөн ийм санааг тэмдэглэсэн байдаг. /1,226/ Түүнчлэн У.Гонгоржав “Тэр үеэс зөв харвах сургууль сорил нь нэг талаар тоглоом наадам, бие бялдыг чийрэгжүүлэх, нумын эрс даацыг шалгаж сайжруулах, нөгөө талаар ан гөрөө, дайн тулалдааны бэлтгэл болж байсан юм” гэж бичсэнийг Монголын зэвсгийн түүхийн судлаач А.Дамдинсүрэн өөрийн бүтээлдээ тэмдэглэсэн байна. /5,44/

**2. Монголын эртний улсуудын үе.** Энэ үед Монголын анхны төр улс Хүннүгийн /МЭӨ III зууны/ үеэс Их Монгол улс байгуулагдах /МЭӨ XII зуун/ хүртлэх үеийг хамарч байна. Монголчууд анхны төр улсаа үүсгэн байгуулж, төрсөн газар нутаг, гол голомтоо хамгаалах, үр хүүхэд, хойч үеэс сурган хүмүүжүүлэхэд нум сумыг гол хэрэглүүр болгож байсан түүх, уран зохиолын баримт бүтээл арвин байдаг.

Эртний овог, аймгуудын өсөлт, хөгжилт, тэдгээрийн өөр хоорондын тэмцлийн улмаас эгэл ангийн зэвсэг байсан нум сум нь байлдааны зэвсэг болж хувирсан нь ойлгомжтой. /5,44/, үүний зэрэгцээ эрчүүд, хөвгүүдийн бие бялдар, авхаалж самбаа, эр зоригийг хөхгүүлэх, шалгаруулах үндсэн хэрэглүүр болсон.

Монголчуудын нум sumaар морин дээрээс давхиут дунд харваж агнадаг өвөрмөц арга барил, сургалтын дэг журмыг Унгарын эрдэмтэн Л.Кун “Хүннүгийн арга” гэж нэрлэсэн байдаг. Хүннү гүрний үед монголчууд морин дээрээс харваж намнах талаар гарамгай байсны зэрэгцээ, эрийн гурван наадмын эхлэл хэдийнээ тавигдсан тухай судлаачдын ном, бүтээлд тэмдэглэгдсэн байдаг. /4,17/ Археологийн судалгаа, монголчууд энэ үед хэдийнээ 4 төрөл хэлбэрийн зүймэл нум хэрэглэж байсныг нотолсон. /20,116; 16,206/ Иймээс монголчууд нь нум сумыг боловсронгуй болгоход их эртнээс хувь нэмрээ оруулж иржээ гэж үзэх үндэстэй юм.

**3. Их Монгол улс буюу эзэнт гүрний үе.** Энэ нь Чингис хаан Монголын 80 гаруй аймгуудыг нэгтгэн, тулгар төр байгуулсан /XII зуун/-аас эзэнт гүрэн задарч Манжийн ноёрхол тогтох /1691 он/ хүртэлх үеийг хамрах юм. Энэ үед Монголчууд чухамхүү нум сумны эрч хүчээр дэлхийн талыг эзэлж, их аян дайны завсар цэрэг эрсийг амраан хөгжөөхдөө нум sumaа ашиглаж байсан. Р.Зориг /1960/ “Монгол ардын спорт” хэмээх номондоо монголчууд Хабул хааны үед харвах намнах наадмыг булцуут сум хийж үлддэг байсан тухай өгүүлсэн байдаг. /8,17-18/ Эндээс үзэхэд булцуут sumaар харваж наадах болсон үе ихээхэн дээр цагаас эхлслэтий байна.

Тэр үеэс өнөөдрийг хүртэл хадгалагдаж ирсэн харваануудын төрөл зүйл үүсч эхэлсэн бололтой. Тухайлбал, монголчууд 1225-1226 оны үед Сартуулыг байлдан дагуулсны дараа “Буга цочих” /Буга Сочигай/ гэдэг газарт цэрэг эрсийг амрааж, сумнуудын зэвийг бургас модны үндсээр сольж, чөдөр, ногт, цулбуур зэргийг зангидан бай болгон тавьж, харвуулан наадуулсан /12,7;13/ Энэ нь эдүгээгийн Урианхай харвааны эх үүсэл байсан гэж зарим судлаачид үздэг. Түүнчлэн энэ үед хүүхэд барагчид бага /3-4/ наснаас нь нум sumaар харваж наадуулан авхаалж самбаа, эр чадлыг хөгжүүлж байсан тухай ном зохиолд тэмдэглэгдсэн байдаг. /14,36; 7,25/

Тухайлбал К.Доссон “История монголов” номондоо Чингис хааны хөвгүүд /Хубилай, Хулагу хоёр/ 9-11 настайдаа буга харваж, намнаж байсныг дурьдсан байна. /6,337/ Чухам энэ үед монголчуудын дундаас олон алдартай баатар эрчүүд, харваачид тодрон түүхнээ тэмдэглэгдсэн төдийгүй, тэднийхээ алдар, амжилтыг тэмдэглэн, хөшөө дурсгалыг босгосон нь эдүгээ спортын амжилтын батлагаа нотолгоог тэмдэглэж үлдээх сайхан уламжлалын эхлэл байсан гэж үзэж байна. /13,42-43/ Иймээс энэ үе нь монголчуудын сурын харвааны хөгжилд ихээхэн чухал түүхэн үе юм. Үүнтэй холбоотой олон баримтыг “Монголын нууц товчоо” /11/, “Хөх судар”/9/ зэрэг түүхэн зохиолуудаас олж үзэх боломжтой. Тэр

бүү хэл, эмэгтэйчүүд эрчүүдийн нэгэн адил нум сүм агсаж харваж, намнаж байсан түүх ч бий.

**4. Манжийн эрхшээлийн үе.** Энэ үе нь Халх монголчууд Манжид дагаар орсон 1691 оноос 1911 онд Богд Жибзундамба хутагтыг шашин, төрийг хослон баригч хаан гэж өргөмжлөх хүртэлх үеийг хамрах юм.

Энэ хугацаанд манжийн төрөөс монголчуудын талаар олон хатуу бодлого барьж байсны нэг нь сурын харвааг хориглосон явдал юм. Энэ нь нэг талаас нум сүм нь цэргийн зэр зэвсэг байсан, нөгөө талаас олон эрчүүд нэг дор цугларч зохион байгуулалтанд орохоос болгоомжилсонтой холбоотой байсан. Энэ талаар манай ахмад судлаач О.Намнандорж: /1957/ “Монгол улс Манжид дагаар орж, тэдний ов мэхэнд автагдаж боол зардас нь болсноос хойш энэхүү үндэсний биеийн тамирын чухал сурлага бараг бүрмөсөн унтраав” /12,13/ гэж бичсэн байдаг. Гэхдээ энэ үед зөвхөн долоон хошуу даншиг наадмын сур, Хэнтийн сур гэх мэт хэдхэн газар сур харвах болж, бусад олон нийтийн чанартай харвуул явахгүй болсон байна. Эдгээрийг ихэвчлэн хаад, ноёд явуулдаг байжээ.

Харин Манжийн сүүлчийн хаан Бадаргуулт төрийн 2-р /1876/ онд сурын анхны дүрмийг Хүрээний сайдуудаас гаргаж, /10,16/ шашны ёслолд сур харваж наадам хийдэг болсон байна. /Гэхдээ хожим энэ нь сурын харвааг хориглох нэгэн шалтаг болсон тухай хожим дурьдах болно/. Энэ үес сурын харваа нь эрх мэдэл бүхий хүмүүсийн баталсан тусгай дэг жаягийн дагуу явах үе эхэлсэн бололтой. Мөн харвах бөмбөгийг анх модоор хийдэг байсныг Бадаргуулт төрийн үед сураар хийх болж, энэ тухай хууль тогтоосон гэдэг /8,21/. Тэр нь эдүгээгийн сурын байг харвадаг харвааны эхлэл байсан ч байж болох юм.

**5. Олноо өргөгдсөн Монгол улсын үе.** Энэ нь 10-аадхан жилийг хамарсан богинохон үе боловч монгол үндэсний сурын харвааны хөгжилд онцгой байр эзэлдэг юм.

Олноо өргөгдсний 2-р онд /1912/ цэргийн яамнаас Дотоод яаманд илгээсэн нэгэн бичигт Нийслэл хүрээнд түшмэл, цэрэг хуралдуулж бөмбөг намнуулан сур харвуулж, эрийн эрдмийг боловсруулахыг хүссэн байдаг /12,13/ ба улмаар аймаг хошуудад ард, тайж нарыг албан журмаар татаж, 1-2 сарын хугацаатай сурын сургуульлалт хийлгэдэг болсон. Түүнчлэн “Сур, бөмбөг харвах ёслолыг явуулах нь” хэмээх зарлигийг гаргаж даган мөрдөж байжээ. /12,13-14/. Ингэснээр үндэсний сурын харваа орсон нутаг, хошуудад сэргэн дэлгэрч эхэлсэн үе юм.

**6. Ардын ардчилсан төрийн үе.** Энэ үед 1921 онд Монголд ардын эрхт засаг тэр тогтсоноос 50-иад он хүртэлх хугацаа хамрагдана. Ардын засгийн анхны баяр наадмыг үндэсний уламжлалын дагууд явуулснаар сумын харваа нь төрийн баяр наадмын үндсэн хэсэг болж хөгжиж эхэлсэн юм. Мөн 1923 оноос цэргийн баяр наадмыг ардын засгийн наадамтай дараалуулан хийх болоход ч эрийн гурван наадам дээр үндэслэн явуулах болсон /9,65/. Энэ үес бөхчүүд, сурчид, уяачид нь хошуу нутгийн оноо тушаалаар биш сайн дурын үндсэн дээр оролцдог болж, наадмаа уралдуулах морь, барилдах бөх, харвах сурчдын тоонд тохируулж чөлөөтэй хийх журам тогтоосон гэдэг. Энэ нь чухамдаа өнөөдрийг хүртэл үргэлжлэн яваа уламжлал болой.

Харин 1930-аад оны сүүлийн хагасаас ортодокс коммунистууд засгийн эрхийг авсан үеэс 1950-иад оны дунд үе буюу авторитар дэглэм тогтоох хүртэлхи хугацаа нь сурын харвааны түүхэнд богинохон ч боловч ихээхэн тоогүй үе байсан бололтой. Энэ үед үндэсний уламжлалт ёс заншил, өв уламжлалаа хадгалах аливаа оролдлогыг “хувьсгалт” ёсны эсрэг үйл гэж үзэж хориглон хязгаарлаж байсан. Үүнтэй уялдан сур харвах наадмыг ч хаад ноёд, язгууртны тоглоом, шашны зан үйлтэй холбоотой гэж үзэж хориглосон байлаа. Энэ үед асар олон тооны нумыг тас тайрч, морины хөлсний хусуур хийсэн тул сурын харваа эргэж сэргэх материаллаг бааз үгүй болоход хүрсэн юм.

Хэдийгээр 1940 онд МХЗЭ-ийн Төв Хорооны дэргэдэх Биеийн тамирын төв зөвлөлд Сурын товчоог байгуулсан ч нэг их дорвитой үйл ажиллагаа явагдаагүй бололтой. /3,58/

Харин улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх 2-р таван жилийн төлөвлөгөөнд /50, 51, 53, 54 онд/ тодорхой тооны нум сумыг БНХАУ-д захиалж хийлгэх, сур харвах, хүмүүсийг харваанд сургахаар тусгасан нь сурын харваа эргэн сэргэж хөгжихийн эхлэл болсон байна.

**7. Социалист төрийн үе.** Энэ үе нь 1950-иад оны дунд үеэс 1990 он хүртэлхи хугацааг хамрах бөгөөд үндэсний сурын харвааг орчин үеийн спортын түвшинд гартал хөгжүүлсэн ихээхэн чухал үе юм. Тухайлбал, үндэсний сурын харваа нь удирдлага, зохион байгуулалт, харвуул-тэмцээний дүрэм журмын хувьд орчин үеийн спортын хэм хэмжээнд хүрч шинэчлэгдсэн бөлгөө.

БНМАУ-ын Сн3-ийн дэргэдэх БТС-ын хорооны гишүүдийн 1955 оны II сарын 19-ны хуралдаанаар "Спортын нэгдсэн ангилалын дүрэм" батлагдсан бөгөөд сурын харваагаар спортын зэрэг, цол олгох тухай заалт орсон байна.

Түүнчлэн МАХН-ын Төв Хороо, Сн3-ын 1956 оны II сарын 6-нд гаргасан тогтоолд үндэсний спортын дүрмийг боловсруулж гаргах тухай заасан байна. 1959 онд БТС-ын хорооны сурын товчоог өргөтгөж сурын холбоог байгуулсан ба мөн энэ үеэс улсын аварга шалгаруулах харваа /1960/, залуучууд, оюутны спартакиад /1959/, бүх ард түмний спартакиад /1961/, бүсийн харваа /1970/, есвэр үеийн улсын аварга шалгаруулах харваа гэх мэт олон төрлийн харвуул тэмцээнүүдийг тодорхой үечлэл, системтэй явуулах болсон байна. Эдгээр бүх төрлийн харвуул-тэмцээний зардлыг улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлж байсан нь үндэсний сурын харвааг төв, хөдөөд хөгжүүлэх чухал хүчин зүйл болсон юм.

Харин Халх харвааг голчлон хөгжүүлсэн тул бусад төрлийн харваа төдийлөн өргөн дэлгэрэх боломжгүй байжээ. Харин өөрчлөлт, шинэчлэлтийн өмнөхөн үеэс баяр наадамд буриад сурын харвааг харвуулдаг болж эхэлсэн юм.

**9. Өөрчлөлт, шинэчлэлтийн үе.** Энэ үед 1990-2002 он хамрагдах бөгөөд энэ нь зөвхөн үндэсний сурын харваа бус монгол орны нийгэм, улс төр, здийн засаг, оюун ухааны бүх хүрээнд өөрчлөлт шинэчлэл хийгдсэн үе юм.

1990 оноос MYCX нь төрийн бус байгууллагын статустайгаар үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн нь санхүү-эдийн засгийн хувьд харьцангуй хүнд үе байсан ч нөгөө талаар үндэсний үзэл, хандлагын идэвхижлийн үе байсан тул үндэсний спортод олон түмний бусад төрлийн харваа хөгжиж дэлгэрэх таатай нөхцөл боломж бүрдсэн байна.

Энэ хугацаанд үндэсний сурын харвааг ивээн тэтгэх шинэ хандлага бий болж, олон аймаг, хотод шинэ баг харваачид бий болсноос гадна буриад, урианхай харваа улам өргөжиж, эдгээр харваагаар улсын аварга шалгаруулах харваанууд явагддаг болжээ. Түүнчлэн Урианхай сурын холбоо байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн юм.

Мөн энэ хугацаанд MYCXолбооны болон халх сурын харвааны дүрэм журмууд шинэчлэгдэж боловсронгуй болсон билээ. Урианхай харваагаар спортын зэрэг цол олгох болзол шинэчлэгдсэн байна. Энэ бүхний дунд харваачдын хүрээ тэлж, нас залуужсан төдийгүй спортын амжилт үлэмж дээшилсэн юм. Үүний баталгаа нь ямар ч харвуул тэмцээнд эрэгтэйчүүдийн хувьд 40 суманд 35, эмэгтэйчүүдийн хувьд 36 суманд 30-аас дээш онож түрүүлэх болсон төдийгүй сурын харвааны түүхэнд анх удаа Эрдэнэт хотын Хангарьд клубын харваач Ш.Даваахүү /1995/ 40 суманд 40 оносон явдал юм.

Энэ үеийн бас нэг онцлог нь CYCX-оос багийн харвааг хөгжүүлэх чиг бодлогыг баримталж, улсын аварга баг шалгаруулах харвааг явуулдаг болсонд оршино. Үүний үр дүнд бараг бүх аймаг баг харваачидтай болсон ба Эрдэнэт

/Орхон аймаг/, Өмнөговь, Дундговь зэрэг олон аймагт шинэ залуу харваачидтай хүчтэй багууд бий болсон.

**9. Шинэ өрнөлтийн үе.** Энэ үе нь 2003 оноос эхэлж байгаа юм. МҮСХ, сурчдаас гаргасан санаачлагыг дэмжиж, Монгол улсын Ерөнхийлөгч 2002 оны 10-р сарын 11-нд "Үндэсний сурын харвааг хөгжүүлэх тухай" /№133/-р зарлигаа гаргасан нь үндэсний сурын харвааны хөгжилд шинэ өрнөлтийн үе эхлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн болно.

Энэ зарлиг гарснаар манай орны бүх иргэд, албан байгууллага, аж ахуйн нэгж, төр засгийн удирдах албан тушаалтын үндэсний сурын харваанд хандах хандлагад эрс өөрчлөлт орж, сурын харвааг улс орон даяар эрчимтэй дэлгэрүүлэн хөгжүүлж, 2006 онд Их Монгол улсын 800 жилийн ойт тэмдэглэх үед манай орны бараг бүх сумдад эрийн 3 наадмаа иж бүрдлээр хийх нөхцөл бүрдэх учиртай юм.

Үүнтэй уялдуулан 2003 оноос өсвөр үеийн баг харваачдын улсын аварга шалгаруулах харвааг явуулж эхэллээ. Энэ нь шинэ залуу харваачдыг олноор бэлтгэх, улмаар сурын харваа хөдөө орон нутагт олон нийтийн дэмжлэг авч хөгжихөд удирдлага, зохион байгуулалтын таатай нөхцлийг бүрдүүлэх болно.

Ингэж шинэ нөхцөл, байдалд олон мянган жилийн түүхтэй энэ харвааны зарим хэсэгт зохих хэмжээний шинэчлэл өөрчлөлт орох нь гарцаагүй. Гэсэн хэдий ч 2000 жилийн өмнөөс бүтэц зохион байгуулалт нь бараг өөрчлөгдөлгүй хадгалагдаж ирсэн /18,147/ эвэр элэгтэй, шермэсөн арлалтай нум нь эдүгээ дэлхийд ганцхан манайд байгааг бид хүндэтгэн онцлох учиртай. Энэ нь бүр нэн эртний үзэс эхлэн урт удаан хувьсгал хөгжлийн бодит үр дүн /18,51/ бөгөөд түүний технологи нь асар их үнэ цэнэтэй зүйл тул үүнийг улам бүр шинжлэх ухааны үндэстэй болгож боловсронгуй болгох шаардлагатай нь ойлгомжтой.

#### **Abstract:**

This article is about development of the archery culture of Mongols. The author divided development of archery on 9 stages and specified each stage of development. Especially, contemporary Mongolian archery is reflected concisely.

Ашигласан материал

**Монгол хэлээр**

1. Ф.Энгельс. Өрх гэр, хувийн өмч, төрийн үүсэл. К.Маркс, Ф.Энгельс. Түүвэр зохиол. З боть. III дэвтэр.
2. Базарсүрэн.Ж. Чингис хааны цэргийн зэр зэвсэг. УБ., 2000.
3. Балдандорж.Д. Сурын харваа. УБ., 1976.
4. Гонгоржав.У. Монголын эртний харвуул тэмцээн /эртний судлал-угсаатны зүйн судалгаа/. УБ., 1982.
- 5.Дамдинсүрэн.А. Монголын зэвсгийн түүх. (МЭӨ III зуунаас 1916 он). Улсын хэвлэлийн газар. УБ., 1990.
- 6.Доссон.К. История монголов. т,1. Иркутск. 1937.
- 7.Жиованни Дель Плано Карпини. Монголчуудын түүх. УБ., 1988.
- 8.Зориг.Р. Монгол ардын спорт. УБ., 1960.
- 9.Инжинаashi.В. Хөх судар. Тэргүүн дэвтэр
10. Магсарсав хурц. Долоон хушуу наадам. УБ., 1960.
- 11.Монголын нууц товчоо. УБ., 1975.
12. Намнандорж.Д. Сур харвах, намнах тухай. Улсын хэвлэлийн газар. УБ., 1957.
13. Пунцагдорж.Ц. Алтайн урианхай харваа. Өлгий 1994.

**Орос хэлээр.**

14. Джованно Дель Плано Карпини. История монголов. В кн."Путешествия в восточные страны Плано Карпини" №7, 1976.
- 15.Окладников.А.П. Погребние бронзового века в Ангарской тайге. КСИИМК, VIII, 1940.
16. Худяков.Ю.С. Вооружение средневековых кочевников южной Сибири и Центральной Азии. Новосибирск. 1986.

**Англи хэлээр.**

17. Greeb.H.A. Studies in Early Chinese Culture. American comneil of Learned Societe. "Studies in Chinese and Related Civilisations", 3. 1948.
18. John S.Major the Land and people of Mcngolia.J.B.Lippincon. New York. 1990.